

10th
ANNIVERSARY



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

ЖИЛИЙН ТАЙЛАН

2023



ИХ БОГД УУЛ
Монгол улс, Баянхонгор аймаг

www.bogdbank.com





 **ИХ БОГД УУЛ**
Монгол улс, Баянхонгор аймаг

АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

- БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА
- БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ
- ДОТООД АУДИТ
- ЭРСДЭЛИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН ГАЗАР
- ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
- БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
- БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
- ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА
- БИЗНЕС БАНКНЫ ГАЗАР
- ЗЭЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР
- ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА
- ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
- САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Богд Банк нь 2014 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш орон даяар нийт 16 салбараар дамжуулж, харилцагч нартаа үйл ажиллагаа явуулж, улам өргөжин тэлсээр байгаа ба тэр дундаа жижиг, дунд бизнесийн зээл нь нийт зээлийн багцын талаас илүү хувийг бүрдүүлдэг ба худалдаа, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийг түлхүү дэмжиж байна. Мөн тус банк нь Монгол Улсын банкны реформын хүрээнд 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлж, олон нийтийн банк болсон анхны банк юм.

Богд банк нь одоогоор нийт 16 салбараар дотооддоо харилцагч үйлчлүүлэгчдэдээ хэрэгцээ шаардлагад тохирсон санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлж, олон нийтэд нээлттэй, үнэ цэн, итгэл түгээгч банк байхыг эрхэмлэн 200 гаруй ажилтнаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль, орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс гадна гадаад, дотоодын төслийн зээлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг үр ашгийг нэмэгдүүлэн ажилласаар байна. Бид байгаль орчны бодлогын хүрээнд хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийг бууруулж ажиллахыг зарчим болгодог.

Банкнаас нэвтрүүлсэн салбартаа анхдагч бүтээгдэхүүн үйлчилгээнээс онцолбол: Харилцагч харилцах дансны дугаараа дураараа сонгох, В-point урамшууллын лоялти оноо, хугацаатай хадгаламжийн хоногийг хугацаагаар сонгох, байгууллагын харилцагч нартаа зориулж corporate gateway үйлчилгээг харилцагч нартаа шинээр нэвтрүүлж, харилцагчийн хэрэгцээ шаардлага, цаг үе, технологийн дэвшлийн хослуулан ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Дэлхийн шилдэг стандарт, туршлага, шинэ үеийн хандлага боломж, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг төдийгүй ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч банк байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО


Харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчдынхаа сэтгэл ханамжийг тэнцвэртэй, тогтвортой хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн үзүүлэлтээрээ олон улсын жишигт хүрсэн, харилцааг эрхэмлэсэн, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч, технологид суурилсан банк байна.








ҮНЭТ ЗҮЙЛС

Банкны ажилтан бүр эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ/TRUST гэсэн монгол, англи үгээр товчлогдон илэрхийлэгдэх эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг цаг ямагт мөрдөж ажиллана.

БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ЕРӨНХИЙ АУДИТОР




ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ




Г.САРУУЛ
Гүйцэтгэх захирал



С.ОРГОДОЛ
Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч



Б.БИЛЭГТ
Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал



М.АЛТАНБАГАНА
Бизнес банк хариуцсан дэд захирал



М.АЛТАНЗҮРХ
Мэдээлэл технологи хариуцсан дэд захирал



Ч.БАНЧИН
Бизнес хөгжил хариуцсан дэд захирал



С.ОТГОНЖАРГАЛ
Зээл хариуцсан дэд захирал



М.БАТ-ӨЛЗИЙ
Санхүү хариуцсан дэд захирал



Э.ГАН-ЭРДЭНЭ
Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал



ДОТООД АУДИТ



Банкны дотоод аудитын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд байх Дотоод аудитын газар хариуцан ажилладаг. Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, бодитойгоор үзүүлж байна. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх удирдлага болон бусад нэгж, үйл ажиллагаанаас хараат бус байдаг ба ажлаа ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай сайжруулах ажлуудыг цаг тухайд нь хийлгэдэг.

Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан арга, аргачлалын үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд ТУЗ-өөс баталсан аудитын төлөвлөгөөний дагуу баталгаажуулалт хийж, банкны дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулах, гарсан алдаа, дутагдлыг засах, үйл ажиллагааг сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлага болон газар, нэгжид мэргэжлийн зөвлөмж өгч ажиллаж байна.

Тус газар нь Дотоод аудиторудын олон улсын институт (IIA Global)-ээс гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework)-г үйл ажиллагаандаа жишиг болгон ажиллаж байна. Мөн мэдээллийн технологийн аудитыг COBIT-2019 стандартад нийцүүлэн хийж, дотоод аудитын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна банкныхаа эрсдэлийг бууруулах, хамтын ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллаа.

Тайлант 2023 он нь Дотоод аудитын газрын хувьд дараах онцлог бүхий жил байлаа. Үүнд:

1. Ажилтнуудаа сургах, хөгжүүлэх, боловсруулах чиглэлд идэвхитэй ажилласан, түлхэц үзүүлсэн, улмаар ажилтнуудаас маань Монгол улсын цол зэргийг авсан жил байв,
2. Дотоод ажил, аудитын аргачлал, үйл ажиллагааны автоматжуулалтыг сайжруулав.
3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд аудитын тайлангуудыг танилцуулж, Дотоод аудитын газраас гаргасан санал, дүгнэлт, үнэлгээ, зөвлөмжийн гүйцэтгэлийг тухай бүр авч хэлэлцэн, бүхий л шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.



ЭРСДЭЛИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН ГАЗАР

ОРОН СУУЦНЫ ЖИШИГ ҮНЭЛГЭЭНИЙ АВТОМАТЖУУЛАЛТ

Зээлийн барьцаа хөрөнгийн жишиг үнэлгээ буюу "Нийтийн зориулалттай орон сууцны ҮХХ-н үнэлгээ"-г шинэчлэн батлуулж апплейкшн болгосноор зээлийн үнэ цэнийн бууралтаас сэргийлэх, мөн санаатай болон санамсаргүй алдаатай үйлдэл хийх, залилангийн шинж чанартай үйлдлээс сэргийлэх боломжтой болсон.

Барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх хугацааг 5-10 минутаар багасгасан.

ОУ-Н СТАНДАРТЫН ХӨРВӨХ ЧАДВАР, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТООЦООЛОЛ

Базелийн стандартад заасны дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлалыг холбогдох журмын дагуу тооцож, макро стресс тест хийж, богино хугацааны бизнес загварыг үнэлсэн.

ОУ-н стандартын дагуу бизнесийн загварыг үнэлж, дэлхийн түвшиний меннежменттэй болох боломжийг бүрдүүлсэн.

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ 113% ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН

Чанаргүй зээлдэгчид шаардлагатай арга хэмжээг авч ажилласнаар нийт 2.27 тэрбум төгрөгийг мөнгөөр төлүүлж, ББГ-тай хамтран 24.33 тэрбум төгрөгийн ӨБХ-өөр зээл төлүүлж, холбогдох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 8% -аас хэтрүүлэхгүй байхад хянаж ажилласан. 13.7 тэрбум төгрөгийн зээлийн төлүүлэхэд шүүхийн байгууллага, харилцагчийн эвлэрийн процессыг амжилттай гүйцэтгэсэн.

2.27 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг мөнгөөр төлүүлсэн

ХАРИЛЦАГЧИЙН ХУВИЙН ХЭРГИЙГ ЦАХИМЖУУЛСАН

Нийт 9 салбарт газар дээрх хяналтыг хэрэгжүүлж хувийн хэргийн бүрдэл бүрэн, эцсийн өмчлөгчийг тодорхойлсон 587 харилцагчийн баримт, материалыг шалгаж 84%-н гүйцэтгэлтэйгээр цахимжуулж хуулийн хэрэгжилтийг хангаж, бичиг баримт алдагдах эрсдэлээс сэргийлж, баримт бичгийн хадгалалт, хяналтыг сайжруулж ажилласан.

Харилцагчийн хувийн хэргийг шалгахад 1-14 хоног зарцуулсан хугацааг хэмнэсэн. DocTime системээс 5 минутын дотор харах боломжтой.

ГҮЙЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫГ АВТОМАТЖУУЛСАН

2023 онд дараахь 4 дүрмийг шинээр үүсгэж, тусгай хяналтын 2 тайланг шинээр хийлгэж хяналтыг сайжруулсан

1. ЭНУГ-н гүйлгээний хяналт
2. Гүйлгээ хийхийг хориглосон улс
3. Гадаад гүйлгээ хийхэд тусгай зөвшөөрөл авах
4. Данс устгах

Тайлан:

1. МУТС-н тусгай хяналт дотоод гүйлгээ
 2. МУТС-н тусгай хяналт ОУ-н картын гүйлгээ
- Гүйлгээний хяналтыг автоматжуулсанаар салбар, СУГ, ЭНУГ-н хамтын ажиллагаа, заавар журмын хэрэгжилт сайжирсан.

Теллерийн гүйлгээ хийх хугацаа шат дамжлагыг 2 дахин бууруулсан.


Гүйлгээний хяналт хэрэгжүүлж байгаа ажилтны 1 өдөр зарцуулах хугацааг 1-3 цаг болгон багасгасан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР


- Ажилчдынхаа ая тухтай ажлын нөхцөл бололцоог хангах үүднээс “Уян хатан цагийн нөхцөлтэй ажиллах боломж”, Цалинтай чөлөө буюу “Boss Day”, эмнэлэгт гүүзүүлэх 4 цагийн цалинтай чөлөө зэрэг олон олон боломжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн.
- Ажиллагсдын Цалингийн зээлийн хүү, Орон сууцны зээлийн хүү буурч, 50 сая төгрөг хүртэл App зээлийг тус тус шийддэг болов.
- 7 давхарын засвар Фитнесс төв, Сургалтын заал, ВИП салбар байгуулах төслийг хамгийн хямд өртөг, чанартай бүтээгдэхүүнүүдээр амжилттай хэрэгжүүлж дуусгасан.
- Банкны үйл ажиллагаанд хэрэглэгддэг автомашинуудыг зах зээлийн ханшнаас 42% хямд үнээр 2023 оны цоо шинэ BYD Yuan plus EV ногоон номертой 100% цахилгаан нийт 4 авто машинаар сольж парк шинэчлэл хийв.
- Их дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа эхлүүлэх гэрээ байгуулж, ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийхээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа бөгөөд Салбар тооцооны төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон картын хүргэлт, аж ахуйн хүргэлтийн асуудлыг шийдэж илүү тав тухтай ажиллах боломжийг тус тус олгосон.

ХУНИЙ НӨӨЦ




МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

- Үндсэн системийн өгөгдлийн сангийн сайжруулалтын тохиргоог хийн нөөц төврүү шилжихэд хугацаа зарцуулахгүй болсноор NES системийн алдэйтийн тасалдалгүйгээр тавих боломжтой болсон.
- Эхүүсвэр болон Валют арилжааны модуль нэвтрүүлсэн
- ТИП гүйлгээ хийх боломжийг нэвтрүүлсэн
- Кассын ажилтны урамшуулал
- Мобайл апп-аараа дамжуулан санал хүсээлт авах боломжтой болгосон
- VISA 3D Secure 2.0 нэвтрүүлснээр харилцагчийн e-commerce гүйлгээний аюулгүй байдлыг хангасан.
- И-монголиа лавлагаан дээр суурилсан хялбараар харилцагч бүртгэх данс нээх карт захиалах боломжит бүртгэлийн үйлчилгээ
- И-монголиа лавлагаан дээр суурилсан онлайн скоринг хийгдэж зээлийн хүсэлт илгээх болон шуурхай зээл авах боломжтой болсон.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Орон нутагт орон сууц авах иргэдэд зориулсан ипотекийн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлэв.

Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв.



Азийн Хөгжлийн Банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.

Урьдчилсан хүүт хугацаагүй хадгаламжийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



Засгийн газраас хэрэгжүүлж буй Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ийг дэмжих төслийн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.

ЦойлогсоZ залуусын нэгдэлтэй хамтран хөгжүүлсэн "Compass Community" 4 төрлийн дүр бүхий бүх төрлийн төлбөр тооцоонд ашиглах дотоодын Т картуудыг нэвтрүүлэв.

TsoilogsoZ



Хүүхдүүдийг хуримтлалтай болгох үүднээс эрхийн бичгийг бэлэглэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн.

Үнэнч харилцагч нартаа зориулсан бодлогоо шинэчлэн батлав.



ONLINE SHUURHAI 2.0

ТАЙЛАНТ ОНЫ УРАМШУУЛАЛТ АЯН

- Хадгаламж эзэмшигчдэд зориулсан "Дурсамж түгээнэ" хадгаламжийн урамшуулалт аян
- Эх үрсийн баярыг тохиолдуулан "Итгэл түгээнэ" урамшуулалт аян
- Эх үрсийн баярт зориулсан
- "Их тойруу" шинэ салбарын нээлттэй холбогдуулан хөнгөлөлт, урамшууллын аян
- Дулаанхан намар" тоглолтын тасалбарын урамшуулалт аян
- "Дархан" шинэ салбарын нээлттэй холбоотой хөнгөлөлт, урамшууллын аян
- Дэлхийн хуримтлалын өдөр 2023 урамшуулалт аян

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

БОГД БАНК нь иргэдийн хуримтлалыг дэмжих зорилгоор, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлөө илүү уян хатан болгох, хуримтлал бий болгох дадал зуршлыг нэмэгдүүлэх үүднээс харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж ирсээр байгаа билээ. Бид тайлант хугацаанд хугацаагүй хадгаламжийн зарлага гаргах боломжтой шинэ бүтээгдэхүүн гарган харилцагчидаа санал болгосон. Ингэснээр харилцагч нь өөрийн хэрэгцээндээ нийцүүлэн гүйлгээ хийх боломжтой юм.

Бид тайлант хугацаанд хадгаламж эзэмшигч харилцагчдаа урт хугацааны харилцаа холбоо бий болгох зорилгоор шинээр хадгаламж нээлгэх болон хадгаламжийн хугацаа сунгалт хийх тохиолдолд хадгаламжийн дүнгээс хамааран хугацаатай хадгаламжийн хүүн дээр нэмэлт хүүгийн урамшууллыг олгох аяныг зохион байгуулсан.

Хуримтлалыг дэмжих зорилгоор хадгаламж эзэмшигч нь өөрт цугларсан В point урамшууллын оноогоо өөрийн хадгаламжийн данс руу шилжүүлэх боломжийг нэвтрүүлсэн.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Картаар үйлчлэгч байгууллагууддаа зориулан “Онлайн КУБ-ын орлого барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн”-ийг зах зээлд шинээр нэвтрүүлж, бичил, жижиг бизнес эрхлэгч харилцагчид маань интернет банк болон мобайл аппаар дамжуулан зээл авах боломжтой боллоо. Мөн харилцагчдынхаа цаг хугацаа хэмнэж, санхүүгийн гэнэтийн хэрэгцээнд зориулан барьцаагүй түргэн шуурхай “Онлайн шуурхай зээл 2.0” зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлж ажиллалаа.

Монголбанк болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтарсан Хүнсний болон Хөдөө аж ахуйг дэмжих дэмжих төслийн зээлийн хүрээнд хамтран ажиллаж өөрийн харилцагчдаа бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг дамжуулан олгож ажиллалаа.

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Залуус өөрсдийгөө илэрхийлж, шинэ боломж, өөртэйгөө ижил сонирхолтой залуустай нэгдэх боломжийг бий болгох зорилгоор ЦойлогсоЗ залуусын нэгдэлтэй хамтран хөгжүүлсэн “COMPASS COMMUNITY” хэмээх цоо шинэ 4 төрлийн дүр бүхий картыг зах зээлд танилцуулсан юм. Үүнтэй холбогдуулан Богд банк олон улсын болон дотоодын картуудаа ҮНЭГҮЙ ЗАХИАЛАН ХҮРГЭХ үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд та өөрийн банкны апплейкшнээр дамжуулан VISA, UNIONPAY, COMPASS картуудын бүх төрлөөс сонгон захиалах боломжтой бөгөөд тус картдаа зориулан шинээр дансны дугаар үүсгэн картаа үнэгүй хүргүүлэн захиалан авах боломжтой юм.

ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР-2023

Богд банк нь 2023 онд Дэлхийн хуримтлалын өдрийн аяны хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд илүү их ач холбогдол өгч, хүүхэд багачууд болон оюутан залуучуудыг хуримтлалтай болохыг дэмжин олон төрлийн арга хэмжээ, урамшуулалт аянуудыг идэвхтэй зохион байгуулж ажилласан. Үүнд:

Богд банк нь 2023 онд “ИТГЭЛ” хүүхдийн хадгаламжийн 100,000 төгрөгийн эрхийн бичгийг Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Дархан хотын Улсын 7 төрөх эмнэлэгт мөн 32 Ерөнхий боловсролын сургууль, 10 цэцэрлэг нийт 22,000 хүүхдэд бэлэглэсэн.

Ерөнхий боловсролын 32 сургуулийн сурагчдад “Хуримтлалын ач холбогдол” сэдвийн хүрээнд Богд банкны Харилцааны менежерүүд сургалтыг зохион байгуулсан.

Олон төрлийн маркетингийн арга хэрэгслийг ашиглан ХУРИМТЛАЛЫН АЧ ТУС-ын тухай мэдээллийг түгээж, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулан ажилласан.

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид байгууллагын харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн, уян хатан нөхцөлтэй харилцах болон хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Харилцагч нь хугацаатай хадгаламжаа хугацаа дуусахаас өмнө гэрээгээ цуцлахгүйгээр зарлага гаргах боломжтой SMART хугацаатай хадгаламжийг нээж өндөр хүүгийн өгөөжийг авах боломжтой юм.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид жижиг дунд бизнес эрхлэгч болон байгууллагын харилцагчдаа үйл ажиллагааны чиглэл, бизнесийн онцлогт тохирсон бүхий л төрлийн зээлийн үйлчилгээг нэвтрүүлж ажиллаж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй Ноолуур бэлтгэлд зориулан олгох төслийн зээл, Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих төслийн зээл, Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээл, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ийг дэмжих төслийн зээлүүдийн үйлчилгээг харилцагчдаа олгож байна.

Мөн барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нартаа зориулан АХБ-ны эх үүсвэртэй хөнгөлөлттэй нөхцөл бүхий батлан даалттай зээлд хамрагдах боломжтой боллоо.

Зээлийн батлан даалтын сан болон Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвтэй хамтран жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг дэмжих, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд цогц санхүүгийн мэдлэг олгох зорилготой 3 талт хамтын ажлыг эхлүүлэв.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалан санхүүгийн хүндрэл үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, Даатгалын зуучлалын үйлчилгээг салбар нэгжээрээ дамжуулан хүргэж байна. Мөн та зээлийн барьцаа хөрөнгөө хурдан шуурхай даатгуулан үйлчлүүлэх боломжтой. Бид энэ жил даатгал зуучлалын шимтгэлийн орлогыг өмнөх оноос 2.5 дахин өсгөж ажиллалаа.

Богд банк нь дараах даатгалын байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчийн хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээг үзүүлж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БОГД БАНК нь Байгаль орчин, нийгмийн хариуцлага, жендэрийн талаар баримтлах чиглэл, зарчим, банкны удирдлага, ажилтнууд болон харилцагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Банкнаас байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, улмаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулах, Байгаль орчин нийгэм, жендэрийн нөлөөлөөс Банкны үйл ажиллагаа болон Богд банкны харилцагчдад үүсэх эрсдэлийг бууруулах, хянах, удирдах үйл ажиллагааг зохицуулах үүднээс 2022 онд “Богд банкны байгаль, орчин, нийгмийн хариуцлага, жендэрийн эрх тэгш байдлын бодлого” гэсэн баримт бичгийг батлуулж, улмаар үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна. Банк нь анх 2015 онд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг батлуулж байсан бөгөөд, жил бүр тухай бодлого баримт бичгээ шинэчлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирсээр байна.

Бид байгаль орчны бодлогын хүрээнд хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийг бууруулж ажиллахыг зарчим болгож ажиллаж байна.

Бид ТоС-н хэрэгжилтийн ил тод байдлыг сайжруулах үүднээс 2022 оноос эхлэн улирал бүр Богд банкны ТоС-н ажлын хэсгийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан улирлын тайланг өөрсдийн вэбсайтад оруулж ил тод болсон билээ. Мөн бид Хувьцаат компани болсонтой холбогдуулан, хагас жилийн тайлангаа олон нийтэд хүргэсэн ба тус тайланд ТоС-н хэрэгжилттэй холбоотой тусгайлан хэсгийг танилцуулсан. Бид цаашид ТоС-н ерөнхий ойлголт ба олон нийтийг мэдээллээр хангах ажлыг идэвхтэй хэрэгжүүлэхээр төвлөн ажиллаж байна.

ТОС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ. ҮҮНД:

Байгаль орчноо хамгаалах

Монголын банкны холбоо, арилжааны банкууд болон Монголбанк хамтран өнгөрсөн он “Тэрбум мод сан”-г байгаль орчныг хамгаалах, ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод тарих, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх зорилгоор хувийн санхүүжилттэй санг байгуулсан билээ. Тэрбум мод сангийн хүрээнд 37 га талбайд нийт 105,000 гаруй модыг тарьж ургуулах, 20,000 кв ногоон байгууламжийг бий болгохоос гадна 5 жилийн хугацаанд тогтмол арчилж, эргэн хяналтыг хийх юм. Түүнчлэн 70 гаруй шинэ ногоон ажлын байрыг бий болгож, 3 төрлийн шинэ технологи, инновацын шийдлийг нэвтрүүлж, төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн 18,000 гаруй хүүхэд, сурагчдыг ногоон орчинд сурч боловсрох боломжоор хангах юм.

Хүний эрх, нийгмийг хамгаалах

Нийгмийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”-ны талаар банкны нийт ажиллагсдаа хамруулсан.

Бид Тогтвортой санхүүжилттэй холбоотой асуудал нь зөвхөн байгууллага асуудал бус Жендэрийн эрх тэгш байдлын асуудал нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал бус бөгөөд энэ нь Банкны болоод нийт улс орны эдийн засагтай шууд хамааралтай гэж үздэг бөгөөд тайлант хугацаанд Банк нь хүний нөөцийн бодлого болон өдөр тутмын үйл ажиллагаандаа жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллахыг эрмэлзэн ажиллагсдадаа зориулж “Ажлын байран дахь жендэрийн ойлголт”-ын тухай мэдээллийг бэлтгэн тогтмол хүргэн ажиллаж байна. Мөн Олон улсын Udemu төлбөртэй сургалтын платформын эрхийг нийт ажиллагсдадаа олгож, түүгээр Олон Улсын түвшингийн жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг мэдээллийн сургалтуудыг хүргэхээр ажилладаг. Хүний нөөцийн газраас Ажлын байран дээрх жендэрийн эрх тэгш байдлын хангах үүднээс сонгон шалгаруулалт, дадлагажуулалт, албан тушаал дэвшүүлэх, албан томилолт зэрэг үйл явцад жендэрийн эрх тэгш байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажилладаг.

Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

Банк нь ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс Эко автомашины зээл, Ногоон хэрэглээний зээл Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл болон Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээлийн бүтээгдэхүүнийг тус тус нэвтрүүлэн харилцагчдадаа санал болгож байна.

Бид НОГООН зээлийг санхүүжүүлэх болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл олгох зорилгоор гадаадын Triple Jump хөрөнгө оруулалтын сангаас болон АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацаас (DFC) санхүүжилт тус тус амжилттай татсан

Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Богд банк нь Тогтвортой санхүүжилтийн хүрээнд 2023 оны 2-р улиралд “Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим”-тай ЖДҮ-ийн салбарыг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох зорилготой хамтран ажиллах санамж бичигт, “Зээлийн батлан даалтын сан”-тай хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Бид иргэдийн ТоС-ийн ерөнхий ойлголтын тухай мэдлэгийн дээшлүүлэх дээр ач холбогдох өгч, Байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагын тухай мэдээллийг тогтмол маркетингийн сувгаар дамжуулан хүргэж байна.

Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

2023 оны 7 дугаар сарын 07-ний өдрийн 23/69 тоот ТУЗ-ийн тогтоолоор 2023 оны 2 дугаар улирлын татварын дараах цэвэр ашгаас ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа 1,250,000,000.00 ширхэг хувьцаанд ноогдуулан тараахаар шийдвэрлэсэн.

Богд банк нь жижиг, дунд үйлдвэрлэл, тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, санхүүжилтээ нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ажиллаж байгаа билээ. Банк нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд 2 жил болж байгаа бөгөөд тайлант хугацаанд энэхүү зээлийн санхүүжилтээр маш амжилттай үйл ажиллагаагаа явуулж буй “Dental plus шүдний эмнэлэг”-ийг олон нийтэд ил тод мэдээллийг хүргэн ажиллаа.


Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Богд банк ХК нь үер, усны гамшгийн нөхцөл байдлын цагт Онцгой Комисс, Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон гамшгийн бүсэд ажиллаж буй бүх аж ахуй нэгжүүдэд зориулан нийт 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Бид ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТоС-н ажлын хэсгийн хэрэгжүүлсэн ажлуудыг улирлын тайлан хэлбэрээр олон нийтэд түгээдэг болсон. Мөн жил бүр Банкны жилийн тайлан болон хагас жилийн гүйцэтгэлийн тайланд тус тус ТоС-н үйл ажиллагааг танилцуулж ил тод байдлын хариуцлагыг дэмжин ажиллаж байна.

Манлайлан үлгэрлэх

Богд банк нь эх дэлхийдээ ээлтэй, нийгэмдээ эерэг, залуусын амьдрах хэв маягт шинэчлэлтэд хувь нэмрээ оруулах зорилгын хүрээнд “Update Festival 2023” ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Уг арга хэмжээ нь дэлхийн дунджаас 176 дахин бага нүүрсхүчлийн хийг ялгаруулсан анхны арга хэмжээ бөгөөд нийт 15,000 залуусын нэгтгэж чадсанаараа онцлог болсон арга хэмжээ юм.



БИЗНЕС БАНКНЫ ГАЗАР

Бид 2023 онд үйл ажиллагаа тэлж, банк санхүүгийн үйлчилгээгээ хүртээмжтэй хүргэх зорилгоор 3 салбар нэгж шинээр нээв. Үүнд: Илүү тав тухтай орчин үйлчлүүлэх боломжтой Прайм салбар, Сүхбаатар дүүрэгт Их тойруу салбар, орон нутгийн 2 дахь салбар буюу Дархан-Уул аймагт шинэ салбар нээж харилцагчиддаа илүү ойртоло. Ингэснээр Улаанбаатар хотод 14, Орон нутагт 2 салбартай болов.

1. Салбарын ашигт ажиллагаа өмнөх жилээс 173% өсч 21.5 тэрбумд хүргэж өмнөх жилийн ашгийг цэвэр 9.05 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв.
2. Эх үүсвэрийн багцыг цэвэр 142.9 тэрбум өсгөж өнгөрсөн оноос 2 дахин өндөр дүнгээр өсгөж, 351.7 тэрбумд хүргэв. Тус онд 16075 шинээр харилцагч бүртгэж, нийт харилцагчийн тоог 92476 хүргэв.
3. Зээлийн багцыг өмнөх оноос 101.7 тэрбумаар цэвэр өсгөж, 306.3 тэрбумд хүргэв. Банкны нийт зээлийн багц 312,5 тэрбум төгрөгт хүрэв. Тус онд 16870 харилцагч нарт 383.9 тэрбум төгрөгийн зээлийг шинээр судлан олгов. Түүнчлэн Банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор экспресс машины зээлийн аянг санаачлан хэрэгжүүлж 1332 харилцагчийн 40,8 тэрбум төгрөгийн зээлийн багцыг 28,8% -гээр буюу өндөр хүүтэй багцаар бүрдүүлэв.
4. Чанаргүй зээл болон анхаарал хандулах зээлийн багцад эзлэх хувь өмнөх оноос буурч, эрсдэлийн бодлогод баримтлах хувиас бага буюу чанаргүй зээлийн хувь 3.4%, анхаарал хандуулах зээл 9.8% хүртэл бууруулж сайн үр дүнтэй ажиллав.
5. Монгол Ипотекийн корпорацаас хэлэлцээр хийсний хүрээнд 3,6 тэрбум төгрөгийн багцыг 30% хямдруулан авч 2023 оны ашигт ажиллагаанд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгээр 830 сая төгрөгийн ашгийг оруулав.
6. Бөөний зээлийн бүтээгдэхүүнийг санаачлан гаргаж Нийт 3н ББСБ-с 46,4 тэрбум төгрөгийн багцыг бүрдүүлэн хамтран ажиллаж зээлийн хүүгийн орлогод 2,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв.
7. Борлуулалтын сувгийг нэмэгдүүлж Орон нутагт-1, Улаанбаатар хотод 2 салбарыг шинээр нээв.
8. Зээл төлүүлэлтийн албыг байгуулж чанаргүй зээлийн тоог өмнөх оноос бууруулж чанаргүй зээлийн эзлэх хувийг 3,4% хүртэв. Мөн 2530 зээлдэгч нартай амжилттай ажиллаж 10,7 тэрбум төгрөгийн зээлийн төлүүлж эрсдэлийг бууруулав.
9. Зээлийн судалгааны албыг байгуулж зээлийн судалгаа болон чанарыг сайжруулж судалгааны албаар дамжин 81,6 тэрбум төгрөгийн судалгааг хийж 47 тэрбум төгрөгийн зээлийг батлуулан олгов.



ЗЭЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

- 2023 онд 17,393 зээлдэгчид нийт 384.4 тэрбум төгрөгийн зээл олголт хийж зээлийн багц өмнөх оноос 50%-иар өслөө.
- Анхаарал хандуулах зээлийн багц 9.8%, чанаргүй зээлийн багц 3.4%-тай гарч, тавьсан зорилгодоо хүрсэн байна.
- Нийт олгосон зээлийн 34%-д эрсдэлийн дүгнэлт гаргаж нэгж зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлээр ажиллаж байна.
- Зохицуулагч байгууллага болон гадны хөрөнгө оруулагчдыг зээлтэй холбоотой тоон мэдээллээр цаг тухайд нь үнэн зөв бүрэн мэдээллээр ханган ажиллаа.
- Хөндлөнгийн болон дотоод аудитын өгсөн зөвлөмжийн дагуу хэрэг бүртгэлийг төвлөрүүлж ажиллалаа.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

DFC-тэй байгуулсан санхүүжилтийн гэрээний хүрээнд хоёр дахь олголтыг амжилттайгаар хүлээн авсан.

АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацтай (DFC) 15 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээг 2022 оны 12 сарын 23-ны өдөр байгуулсны дагуу хоёр олголтоор 15 сая ам.долларыг ЖДҮ тэр дундаа ногоон болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихээр амжилттай татсан байна.

Enabling Capital/EMF Microfinance Fund хөрөнгө оруулалтын сангаас 3 дахь удаагаа амжилттайгаар санхүүжилтийг татсан

2023 оны 3 сарын 13-ны өдөр гурав дахь зээлийн гэрээг байгуулан 4 сая ам.долларын дунд хугацааны ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн санхүүжилтийг Enabling Capital/EMF Microfinance Fund-аас хөрөнгө оруулалтын сангаас амжилттай татсан байна.

Triple Jump/Dutch Good Growth Fund хөрөнгө оруулалтын сангаас амжилттайгаар анхны санхүүжилтийг татсан

Triple Jump-тай харилцааг эхлүүлэн, магадлан шалгалтыг (due diligence) амжилттай давж, 2023 оны 12 сарын 11-ны өдөр анхны зээлийн гэрээг байгуулан 8 сая ам.долларын дунд хугацааны санхүүжилтийг татлаа. Энэхүү санхүүжилт нь өмнөх татсан санхүүжилттэй төсөөтэйгөөр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн байна.

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

БОГД банк нь зохицуулагч байгууллагуудаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг банкны Актив, Пассивын удирдлагын бодлогын дагуу тогтмол давуулан биелүүлж ажиллалаа. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 42.3%, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 28.2% тай хангаж ажиллалаа. Үүний үр дүнд дотоодын хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудын итгэлийг хүлээж гадаад валютын урт хугацаат эх үүсвэрийг олон улсаас амжилттай татан төвлөрүүлсэн байна. 2022 оны жилийн эцэс болон 2023 оны хагас жилийн цэвэр ашигаас нийт 2585 хөрөнгө оруулагчиддаа 2 удаа ногдол ашиг тараасан нь санхүүгийн үзүүлэлтүүд болон зохистой харьцаануудыг өндөр түвшинд хангаж ажилласныг илтгэж байна.

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Мөн бид Монголбанк болон Засгийн газраас хэрэгжүүлж буй ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцож Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгож, дотоодын эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд хувь нэмрээ оруулж ажиллалаа.

ВАЛЮТ АРИЛЖАА


БОГД Банк нь дотоодын валют арилжааны зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж ажилласан бөгөөд цахим банк болон салбар, тооцооны төвүүдээр дамжуулан харилцагчдын валют арилжааны эрэлт, нийлүүлэлтийг 8 төрлийн валютаар хурдан шуурхай, уян хатан нөхцөлөөр хангаж ажиллалаа. 2023 онд Монгол улсын эдийн засаг тэлж, гадаад худалдааны дүн нэмэгдсэний дагуу харилцагчдын валютын эрэлт өсөлттэй байсан бөгөөд тус хугацаанд банкны валют арилжааны эргэлт өмнөх оны мөн үеэс 12% аар өссөн байна. Мөн харилцагчдынхаа валютын эрэлт, нийлүүлэлтийг хангах, импорт, экспортын бизнес эрхэлдэг дотоодын томоохон харилцагч байгууллагуудаа ханшийн эрсдлээс хамгаалах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болох своп, форвард арилжааны хэлцэл санал болгож, хэрэгжүүлж ажиллалаа.



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ

Нийт хөрөнгийн дундаж өсөлт 2017 оноос - 46%




НИЙТ ӨР ТӨЛБӨР


Нийт өр төлбөрийн дундаж өсөлт 2017 оноос - 52%



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ




ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА




ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

Зээлийн үлдэгдлийн дундаж өсөлт 2017 оноос - 87%




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Өөрийн хөрөнгийн дундаж өсөлт 2017 оноос - 30%




ХҮҮНИЙ ОРЛОГО

Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 55%




ХҮҮНИЙ ЗАРДАЛ

Хүүний зардлын дундаж өсөлт 2017 оноос - 86%




ЦЭВЭР АШИГ

Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 66%



ХАРИЛЦАХ ХАДГАЛАМЖ

Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 66%



ROA 5.15%	ROE 23.45%	ОРЛОГО ЗАРДЛЫН ХАРЬЦАА 1.5	ЦЭВЭР ХҮҮНИЙ МАРЖИН 7.2%	КАПИТАЛ ҮРЖҮҮЛЭГЧ 5.03	НЭГ АЖИЛТАНД НОГДОХ АШИГ 124.8 сая/төг/өгөр
---------------------	----------------------	--------------------------------------	------------------------------------	----------------------------------	--

Д/Д	Санхүүгийн үзүүлэлтүүд	Гүйцэтгэл 2023Q4	Төлөвлөгөө 2024Q4	Өсөлтийн хувь
1	Нийт актив /Сая.төг/	712,324.00	1,108,275.00	55.59%
2	Хүүгийн орлого /Сая.төг/	82,562.00	117,545.00	42.37%
3	Хүүгийн бус орлого /Сая.төг/	13,873.00	15,437.00	11.3%
4	Цэвэр ашиг /Сая.төг/	28,201.31	43,080.00	53%
5	ROE	23.45%	26.36%	12.4%
6	ROA	5.15%	5.25%	2%
7	Нийт өөрийн хөрөнгө /Сая.төг/	141,613.00	184,960.00	31%
8	Зээлийн багц /Сая.төг/	312,151.00	609,844.00	95%
9	NPL	3.42%	3.99%	
10	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	42.28%	38%	
11	1-р зэрэглэлийн ӨХ болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	28.23%	23.92%	
12	Зээл/Нийт активын харьцаа	44%	55%	
13	Нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмж /Сая.төг/	124.8	148	



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ



Богд цамхаг, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com